

МОНГОЛЫН ЗАРИМ ТАМГАТАЙ ХУТАГТЫН ШАВЬ НАРЫН НУТГИЙН ЗУРГИЙН АСУУДАЛД

Л.Алтанзаяа

Монголын тамгатай хутагтуудын шавь нарын түүхийг судлахад тэдний нутгийн зургууд нь чухал хэрэглэгдэхүүн болно. Иймд Монгол улсын үндэсний төв архив болон үндэсний номын санд хадгалагдаж байгаа нутгийн зургуудыг судлууштай.

Монгол улсын түүхийн ботиуд болон “Монгол ард улсын угсаатны судлал хэлний шинжлэлийн атлас” дахь газрын зургуудад Монголын тамгатай хутагтуудын шавь нарын нутгийг зурсан байдаг. Мөн тухайлсан тамгатай хутагтын шавь нарын нутгийн зургийн талаар дотоод, гадаадын эрдэмтэн судлаачид бүтээлдээ хөндөн бичжээ. Тухайлбал, Ш. Нацагдорж бүтээлдээ, Нарбанчин хутагт, Эрдэнэ мэргэн ноён хутагтын шавь нарын нутгийн зурагт тулгуурлан нутгийн хэмжээг нь тодорхойлсон¹ бол О.Пүрэв бүтээлдээ, Нарбанчин хутагтын шавийн харьяат нарын нутгийн зурагт тэмдэглэсэн тус шавийн зүүнээс баруун хязгаар хүртэлх газрын хэмжээг ертөнцийн 24 зүгийг заасан хүрдтэй харьцуулсан бүдүүвч зургийг² хийв. Япон улсын эрдэмтэн Фүтаки Хироши, Камимүра Акира нарын бүтээлд Егүзэр хутагтын шавь нарын нутгийн зурагтай холбогдуулан засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг дурджээ.³ Монголын эрдэмтэн Л.Нямсүрэн бүтээлдээ, Жалханз хутагтын шавь нарын нутгийн зургийн талаар танилцуулсан⁴ бол Л.Лхагважав бүтээлдээ, Хамба хутагт номунханы шавь нарын нутгийн зурагт бичсэн 28 газар нутгийн нэрийг⁵, С.Юндэнбат бүтээлдээ, Эрдэнэ бандида хутагтын шавь нарын нутгийн зурагт тэмдэглэсэн хил залгаа хошуу, шавьтай хаана, хэдий хэмжээний газраар хиллэж буйг тодорхойлсон тайлбарыг бичсэн.⁶

¹ Ш. Нацагдорж. Сум, хамжлага, шавь ард. УБ.,1972. 51-р тал.

² О.Пүрэв. Монгол улсын түүхэн газарзүй. УБ.,2004. 179-р тал.

³ Landscapes Reflected in Old Mongolian Maps. Edited by FUTAKI Hiroshi and KAMIMURA Akira. Tokyo.2005.p.31.

⁴ Л.Нямсүрэн. Жалханз хутагт Дамдинбазарын нийгэм, улс төрийн үйл ажиллагаа (1874-1923). УБ.,2006.42-р тал.

⁵ Л.Лхагважав. Хамба номунхан Жамбалдорж. УБ.,2006.116-р тал.

⁶ С. Юндэнбат. Ламын гэгээн шавийн түүх. УБ.,2009.176-р тал.

Л.Алтанзаяа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль
altan_zaya@yahoo.com

Фүтаки Хироши, Камимүра Акира, Э.Равдан, Л.Чулуунбаатар

Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд
МУИС пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012, ISBN 978-99962-72-59-2

Бид илтгэлдээ, Монголын зарим тамгатай хутагтуудын шавь нарын нутгийн зургийн тухай товч танилцуулж, холбогдох саналыг дэвшүүлэхийг хичээнэ. Монголын тамгатай хутагтуудын шавийн захиргаа байгуулагдсан болон түүнийг нь хожим Манж Чингийн төрөөс баталгаажуулсан оныг Халхын жишээгээр танилцуулбал, Жавзандамба хутагтын шавь нар 1639 онд, Зая бандида хутагтын шавь нар 1737 онд, Эрдэнэ бандида хутагтын шавь нар 1737 онд, Чин сүжигт номун ханы шавь нар 1751-1755 онд, Ноён хутагтын шавь нар 1760 онд, Нарбанчин хутагтын шавь 1772 онд, Засагт хан аймгийн Ялгуугсан хутагтын шавь нар 1821-1868 онд, Жалханз хутагтын шавь 1824 онд, Эрдэнэ мэргэн ноён хутагтын шавь нар 1826 онд, Номун ханы шавь нар 1853 онд, Егүзэр хутагтын шавь нар 1864 онд, Наран хутагтын шавь нар 1897 онд, Хамба номун ханы шавь нар 1909 онд тус тус тамгатай болжээ. Харин Монгол улсын үед 1912 онд Шива ширээт хутагтын шавь нар, 1913 онд Сэцэн хан аймгийн Ялгуугсан хутагтын шавь нар тус тус тамга бүхий болсон байна. Энэ нь тамгатай хутагтуудын шавь нарын нутгийн хэргийг албан ёсоор шийдвэрлэсэнтэй уялдах тул шавь нарын нутгийн зургийн асуудалтай холбогдох юм. Тамгатай хутагтын шавь нарын захиргааг баталгаажуулснаар нутгийн зургийг хийлгэж байсан эсэх нь харилцан адилгүй байжээ. Бид өмнө нь Нарбанчин хутагтын шавь нарын нутгийн зургийн тухай 1805, 1854 оны мэдээ⁷, Номун хан эрдэнэ хамбын шавь нарын нутгийн зургийг зуруулахаар болсон 1911 оны мэдээг⁸ танилцуулсан. Дашрамд дурдахад, Манжийн үеийн Хүрээ хошууны тамгатай засаг лам нь угсаа залгамжлах болон эсвэл шавь нараас гардаг байв. Тус хошууны нутгийн зургууд хадгалагдан үлджээ. Харин Хөх нуурын Цагаан номун ханы хошууны нутгийн зургийг бид хараахан олж үзээгүй байна.

Монголд бурханы шашин дэлгэрснээр тухайн үеийн гол суртал болох бурханы шашны хутагтын төрлүүдийг тодруулан, тэдний шавь нарыгн нутагтай болгосон үйл явц Халхын аймгуудад харилцан адилгүй хэрэгжсэн нь XVIII-XIX зууны үеийн зарим хутагтын шашин, нийгмийн байр суурийнх нь өөрчлөлттэй холбоотой. Халхын аймгуудын нутгийн хил зааг тогтоосны дараа хутагтуудын шавь нар аль аймагт харьяалагдсанаас хамааран хутагтад шавь нарын нутгийг тухайн аймгийн засаг хошуудаас өргөж байв.

Одоо мэдэгдэж байгаагаар 1867-1926 оны үед холбогдох Монголын зарим тамгатай хутагтуудын шавь нарын нутгийн зураг 20 гаруй байдгаас 6(?) нь 1867-1911 оны үед, бусад нь түүнээс хойшхи үед хамаарагдана. Ялангуяа 1921 оны зураг цөөнгүй байгаа нь засаг захиргааны өөрчлөлттэй холбоотой юм. Бид холбогдох зургуудыг цахим хэлбэрээр ашигласан тул эх зургийн хэмжээг тодорхойлох боломжгүй байсныг тэмдэглэе.

Манжийн эрхшээлийн үеийн Монголын зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийн зургийн тухай. 1911 оныг хүртэл нутгийн зургуудад Халхын тамгатай хутагтын шавь нарын нутгийн зураг 4, тамгатай хутагтуудын шавь нарын нутгийг багтаан зурсан аймгийн зураг 3 байна.

Бадаргуулт төрийн 33-р он(1907) оны 4 сарын шинийн 8-нд үйлдсэн Жавзандамба хутагтын шавь хар дархад ардын нутгийн зургийн огноон дээр Эрдэнэ шанзудбагийн тамга даржээ.⁹ Уг нутгийн зургийг 7 нүд бүхий улаан дөрвөлжин хүснэгтэд багтаан зурсан бөгөөд хил савын овоодын нэр, тэдгээрийн хоорондын зайг бичжээ. Мөн уул, усыг өнгө ялган дүрсэлж, тэдгээрийн нэрсийг бичсэний дээр ханз үсэгтэй бүхий цаас наалдуулжээ. Тэр тухайд “Жавзандамба хутагтын шавь Дархад ардын нутгийн зах хязгаар нийлсэн газар орны нэрийг байцаасан цэс дэвтэр”-т “Зураг зурах 2 ямх(6,4 см- Л.А)-ын дөрвөлжин хэмжээнд 5 газар(2 км 880 м) бодож нэгэн хэмжээнд хэлэлцэх хуудас наалдуулснаас гадна тэнд Дархад шавь нарын байгуулсан хүрээнд 1308 лам ном уншиж сууна. Басхүү Дархад

⁷ Л.Алтанзаяа. Нарбанчин хутагтын шавийн тухай // ACTA HISTORICA.Tomus IX. Fasc.1-34. УБ., 2008. 184-185-р тал.

⁸ Л.Алтанзаяа. Номун хан эрдэнэ хамбын шавь нарын асуудалд // ACTA HISTORICA.Tomus X. Fasc.1-42. УБ., 2009. 224-р тал.

⁹ Жавзандамба хутагтын шавь хар дархад ардын нутгийн зураг. http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_E_Hs_or_0039. Manuskriptkarte, 1 Bl., 69:66 cm. Katalog Nr. 686.

шавийн ардыг 1 их, 2 бага дарга захирна.”¹⁰ хэмээжээ. Уг зураг дахь зарим овоо хоорондын зайн тэмдэглэгээ нь цэсд тэмдэглэснээс ялгаатай юм. Жишээ нь, Цагаан голын овооноос Оглог голын овоо хүртэл 60 газар(34 км 560 м), дараагийн овоо хүртэл 85 газар(48 км 960 м)¹¹ хэмээсэн бол цэсд 64 газар(36 км 864 м), 70 газар 6 хувь(40 км 665 м) хэмээн тэмдэглэжээ. Иймд Жавзандамба хутагтын шавь хар дархад ардын нутгийн зураг, цэсийг нэг бус удаа үйлдэж байсан бололтой.

Бадаргуулт төрийн 33-р он(1907)-д үйлдсэн Халхын Зая бандида хутагтын шавь нарын нутгийн зургийг даавуун дээр уул, усыг өнгө ялган зуржээ. Хануй, Хүнүйн, Тамир голуудын дагуух уулуудыг тодорхой дүрслэн Зая бандида хутагтын суусан газар, “Буяныг хөгжүүлэгч сүм”, “Өлзий бадруулагч сүм”-ийг тэмдэглэв. Нутгийн эргэн тойрон 10 хэсэгт ямар хошуудтай зах нийлснийг бичжээ. Тухайлбал, нэр бүхий газруудын хооронд Махасамдан, Мөнх-Очир, Даянжалбуу, Наянт, Довчинжамц, Гончигчойжин, Дондовжанцан, Чимэддэлэг, Сандагдорж, Лувсанхайдав нарын хошуудтай зах нийлж нутагладаг хэмээв.¹²

Бадаргуулт төрийн 33-р он(1907)-д үйлдсэн Наран хутагтын шавь нарын зургийг даавуун дээр зурсан бөгөөд огнооны дээр “Наран хутагтын шавьнарыг захирах тамга” хэмээх монгол, манж, төвд бичээс бүхий тамга даржээ.

Дөрвөн зүгийг бичээд хойд зүгт Цагаан даваа, өмнөд зүгт Дагналтай булгийн хооронд “Үнэн ухаант сүм”, Индэрт, Наран хутагтын суусан газар зэрэг зарим газрын нэрийг зурж бичжээ. Харин зүүн, баруун талын захыг тэмдэглэлгүй задгай орхисон байна. Зургийн хойд хэсэгт болон өмнөд хэсэгт бусад ямар хошуутай хэрхэн зах нийлэн савлаж байгааг тэмдэглэсэн байна. Үүнд, “Мөнхүү Цагаан даваанаас Дунд хамар даваа, Хижлиг даваа, Үертийн дунд хамар, Бүлээний ам, Улаантолгой, Буурал үнэгэдийн өвөр, Зүүн бууц, Өндөрцээр Мааньдөрөлж, Тэгшбуянтын ар ихэр бууц, Халтарын бууц, Эхний чандмань, Дунд чандмань, Сайрын дөрөлж, Наран суурь Пүрэвжавын хошуу лугаа зах нийлж нутаглымуй”, “Мөнхүү Онгочулууны овооноос Уушги, Харчулуут, Индэрт хэмээх газрыг дайран Цагаан даваа хүрүүлэн нэгэн аймгийн хэбэй бэйсийн зэрэг гүн Дугаржавын хошуу лугаа зах нийлж нутагламуй.”, “Өмнөд Дагналтайн булгийн баруун уулын овооноос Бэлийн бууц, Мөрөн булаг, Холбоо худаг хэмээх газрыг дайран Онгочулууны овоонд хүрүүлэн Засагт хан аймгийн дэд чуулганы дарга Засагт хан Содномравдангийн хошуу лугаа зах нийлж нутагламуй”¹³ хэмээн бичсэн нь зургийн тэмдэглэгээг нөхсөн ажээ. Харин газруудын хоорондын зайг тэмдэглэсэнгүй байна.

1908 онд үйлдсэн Ширээт хүрээний бүгд лам банди нарыг захирагч засгийн тэргүүн рабжамба блам Наваанбалдангийн хошууны зураг¹⁴ нь 111х63,3 см хэмжээтэй бөгөөд зурагт тус хошуу нь өмнө хойш 150 газар (86 км 400 м), баруун захаар 80 газар урт (46 км 800 м), зүүн баруунш 60 газар өргөн (34 км 600 м) хэмээн бичээд уул ус, айл, хүрээ зэргийг нарийвчлан зуржээ. Нутгийн зах нийлсэн Хишигтийн (Хишигтэн-Л.А) хошуу, Хуучин сүрэг, Шинэ сүрэг, Зүүн Түмэд хошуу, Тангуд халх, Хойд халх, Найман хошуу гэх мэт хошуудын нэрсийг холбогдох зүгт нь тэмдэглэжээ. Гэвч нэрсийн дээр наасан цагаан цааснаа хятадаар бичсэн байна. Уг хошууны өөр нэгэн зураг Монгол Улсын Үндэсний Номын Санд хадгалагдаж байна. Хэвт ёсны 2-р (1910) оны намрын тэргүүн сарын 14-нөө үйлдсэн Ширээт хүрээний бүгд лам банди нарыг захирагч засгийн тэргүүн рабжамба блам Агваанбалдантаны хошууны зураг нь 1908 оны зурагтай харьцуулахад тайлбарыг

¹⁰ Жавзандамба хутагтын шавь Дархадын нутгийн цэс дэвтэр. Монгол Улсын Үндэсний Номын Сан(МУҮҮНС). Гар бичмэлийн сан(ГБС).

¹¹ Жавзандамба хутагтын шавь хар дархад ардын нутгийн зураг. http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_E_Hs_or_0039. Manuskriptkarte, 1 Bl., 69:66 cm. Katalog Nr. 686.

¹² Бадаргуулт төрийн 33-р онд үйлдсэн Халхын Зая бандида хутагтын шавь нарын нутгийн зураг. МУҮНС. ГБС.

¹³ Бадаргуулт төрийн 33-р онд үйлдсэн Наран хутагтын шавь нарын зураг. МУҮНС. ГБС.

¹⁴ Ширээт хүрээний бүгд лам банди нарыг захирагч засгийн тэргүүн рабжамба блам Наваанбалдангийн хошууны зураг// Mongolische Ortsnamen / aus mongolischen Manuskriptkarten zusammengestellt von Magadbyrin Haltod ; mit einer Einleitung von Walther Heissig. Wiesbaden : F. Steiner, 1966. Tafel XVII.

товч бичжээ.¹⁵ Эдгээр зургийн огноон дээр “Ширээтийн хүрээний бүгд лам банди нарыг захирагч тамга” хэмээх тамга даржээ. Мөн зурагт Хадат уулын өмнө Хүрээ хийд, түүнээс нэлээд баруун тийш Хүрээн зээл, таван гэр, дөрвөн гэр гэх зэргээр тодорхойлон бичжээ.

Дашрамд дурдахад, Монгол улсын үндэсний төв архивт хадгалагдаж буй Цогтой гүний хошууны ноён Магсаржавын үед Ялгуугсан хутагтын шавьд таслаж өгсөн нутгийн зураг(1867 он хэмээн дансанд тодорхойлсон)-ийг¹⁶ бид тусгайлан үзэж чадсангүй.

Монгол улсын зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийн зургийн тухай

1913 оны сүүлчээс 1918 оны эх хүртэлх хугацаанд боловсруулан, дагаж шийтгүүлсэн “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийн “Нутгийн хэргийн хууль”-ийн “Нутгийн зураг үйлдүүлэх зүйл”-д “Олон засаг хошууны нутаг газар орны хэмжээ байдлыг нарийн тодорхой зураг зурж, тойрон овоо тэмдэг байгуул. Цөм цаг улирлын тооны бичгийн 8 хөлөл 12 жилийн хүрдний доторхи 8 зүг, 12 салаа 24 зүгийн морин үсгийг өмнөх болгож уул овоонд толгойгоо хойш хандуулан зурагтун. 360 алд газрыг нэгэн газар, 36 алдыг нэгэн хувь, хувьд үл хүрэхийг алдын тоогоор хэмжиж, 25 газрыг нэгэн ямхын хэмжээнд багтааж, дөрвөлжин хүснэгт татаж зүүн этгээд хөх барс, хөхөгчин туулай, өмнө этгээд улаагчин могой, улаан морь, баруун этгээд цагаан бичин, цагаагчин тахиа, хойд этгээд харагчин гахай, хар хулгана, зүүн өмнө орлого, шар луу, баруун өмнө зөвөргүү, шарагчин хонь, баруун хойд этгээд зогсолт, шарагчин үхрийн зүг чигийг үзэж зах нийлэх засаг хошуу лугаа хязгаар уулзах газарт байгуулсан овооны нэр хоорондын хэмжээ, мөнх зүг лугаа тохиолдуулан хэмжиж тодорхой цэс бичиж Дотоод яамнаа мэдүүлэн ирж хянан байцаалгагтун” хэмээжээ. Тухайн үед “Монгол улсын харьяат Их шавь, Халхын дөрвөн аймгийн 43 отог, 92 засаг хошуу”¹⁷ хэмээн Жавзандамба ламын шавь 30 их отгийг ахлуулан Сэцэн хан аймгийн Эрдэнэ Ялгуулсан хутагтын шавь нэгэн отог, Егүзэр ачит зан бадарсан эрдэнэ мэргэн хамба хутагтын шавь нэгэн отог, Засагт хан аймгийн Самади багш, Номун хан Жалханз хутагтын шавь нэгэн отог, Нэвтэрхий сайн Самади багш Ялгуусан хутагтын шавь нэгэн отог, Сайн ноён хан аймгийн Зая бандида хутагтын шавь нэгэн отог, Эрдэнэ бандида хутагтын шавь нэгэн отог, Чин сүжигт номун хан эрдэнэ бандида ноён хутагтын шавь нэгэн отог, Эрдэнэ мэргэн ноён хутагтын шавь нэгэн отог, Нарбанчин хутагтын шавь нэгэн отог, Наран хутагтын шавь нэгэн отог, Хамба хутагт номун ханы шавь нэгэн отог, Шива ширээт хутагтын шавь нэгэн отог¹⁸ хэмээн бичсэн нь нутгийн хэргийн хуулийг засаг хошуудын нэгэн адил дагаж шийтгүүлэх үндэслэл болсон байна. Монголын зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийн зургийг 1911 оноос хойшхи зураг үйлдсэн оны дарааллаар бус, шавь нар захирах тамгатай болсон дарааллын дагуу танилцуулъя.

Олноо өргөгдсөний 3-р(1913) онд үйлдсэн Сайд Сайн ноён хан аймгийн Зая бандида хутагтын шавийн нутгийн зургийг дөрвөлжин улаан хүснэгтэд багтаан уул, ус, зам, хилийг өнгө ялган маш тодорхой дүрслэн зуржээ. Зурагт “Буяныг дэлгэрүүлэгч сүм”, “Өлзий бадруулагч сүм”, “Амгаланг хамгаалагч сүм”, Алтан овоог дүрслэн, нэрийг бичсэн байна. Нутгийн зүүн өмнө хэсэгт “Энэ Хадат хамарын овоонд бэйл Сандагдорж, Сүжигт бэйл Чимиддэлэг, манай гурван хошуу шавийн нутгийн сав мөн Хадат хамарын овооноос Шарбулагийн амны хөтлийн овоо хүртэл 80-ны газар(46 км 80 м) савламуй”, “Энэ Нүхтэд гүн Лувсанхайдав, Бишрэлт бэйл Сандагдорж манай хоёр нутгийн сав уулзвар болох агаад бэйл Сандагдорж манай хоёр нутгийн сав мөн Нүхтээс Гарадын зүүн үзүүр Хадат хамарын овоо хүртэл 120-ны газар(69 км 120 м) савламуй”¹⁹ хэмээжээ.

¹⁵ Ширээт хүрээний бүгд лам банди нарыг захирагч засгийн тэргүүн рабжамба блам Агваанбалдантаны хошууны зураг. МУҮНС. ГБС.

¹⁶ Цогтой гүний хошууны 13 дахь ноён Магсаржавын үед Ялгуугсан хутагтын шавьд таслаж өгсөн нутгийн зураг. Монгол Улсын Үндэсний Төв Архив (МУҮТА).

¹⁷ Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. Монголоос кирилл бичигт буулгасан О.Батсайхан, З.Лонжид, Ч. Хажидсүрэн. УБ., 1995. 180-р тал.

¹⁸ Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. Монголоос кирилл бичигт буулгасан О. Батсайхан, З.Лонжид, Ч. Хажидсүрэн. УБ., 1995. 6-10-р тал.

¹⁹ Сайд Сайн ноён хан аймгийн Зая бандида хутагтын шавийн нутгийн зураг. МУҮНС. ГБС.

Олноо өргөгдсөний 3-р он(1913)-ы 11 сарын 21-нд үйлдсэн Сайн ноён хан аймгийн Эрдэнэ бандида хутагтын шавь нарын нутгийн зургийг даавуун дээр улаан дөрвөлжин хүснэгтэд багтаан уул, ус, замыг өнгө ялган зуржээ. Тамганы дардас үгүй. Зурагт Баянзүрх уулын өмнө талд “Соёлыг бараалагч сүм”, тамгын газрыг, мөн Шаргалжуутын болон Худаг-Уртын өртөөг зурсан. Нутгийн зүүн, баруун хоёр захаар урсах голыг хил савыг тэмдэглэсэн улаан хүрээний гадуур зурсан. Баруун захын “Молцог элсээс Түй голыг дайран 205-ны газар(118 км 80м) нэгэн аймаг хамаарсан жанжин Дайчин ван Гүргэмжавын хошуу лугаа савламуй” хэмээсэн бол зүүн захын ”Сүүл толгойгоос Олстой хүртэл 70-ны газар(40 км 320 м) нэгэн аймгийн Эрдэнэ мэргэн ноён хутагтын шавь лугаа савламуй”²⁰ хэмээн тэмдэглэжээ.

Мөн Олноо өргөгдсөний 11-р он(1921)-ны 4 сарын 18-нд үйлдсэн Сайн ноён хан аймгийн Төрөлх нэвтэрхий номч бишрэлт шадар үйзэн хурц сэргэлэн Эрдэнэ бандида хутагтын шавь нарын нутгийн зургийг 200 нүд бүхий улаан дөрвөлжин хүснэгтэд багтаан зуржээ.

Уг зураг нь 1913 оны зурагтай адил боловч дүрслэл, тэмдэглэлийн хувьд улам нарийвчлалтай ажээ. Жишээлбэл, 1913 оны зурагт “Олстойгоос Эсэри(Сээр) хүртэл 225-ны газар(129 км 80 м) нэгэн аймгийн Ёст засаг Чүлтэмийн хошуу лугаа савламуй” хэмээсний зэрэгцээ Орог нуурын нэрийг бичсэн бол бол 1921 оны зурагт “Сайд Ёст бэйл Чүлтэмийн хошуу лугаа савламуй”²¹ хэмээсний дээр “Орог нуур урт нь 35 газар(20 км 160 м)” хэмээн тодотгон бичжээ. Мөн нутгийн баруун өмнө хэсэгт Сээрээс Зуун мод, Бамбуу дайран Өвөргүн хүртэл 40-ны газар(23 км 40м) язгуураас зах нийлсэн хүн үгүй”, “Өвөргүнээс Заг хүртэл 60-ны газар(34 км 560м) Засагт хан аймгийн бэйлийн зэрэг жонон бэйс Жалцандалайнамжилнаваандоржийн хошуу лугаа савламуй” хэмээсэн нь анхаарал татна. 1773 оны Сайн ноён, Засагт хан аймгийн нутгийн завсар хил тогтоон хэлэлцэж хоёр аймгийн савлан суух нутаг газрын нэрийг бичсэний дотор “Өвөр гүн”²² хэмээх нэр байдаг нь дээр дурдсан газар мөн бололтой. Түүнчлэн захын зарим хэсэгт “язгуураас зах нийлсэн хүнгүй” хэмээсэн нь тус хоёр аймгийн буюу хил залгаа хошуу, шавийн хооронд хоорондын нутгийн өвөрмөц байдлыг илтгэнэ.

Олноо өргөгдсөний 3-р (1913) оны 11 сарын 19-нөө үйлдсэн Сайн ноён хан аймгийн Ухаант сайн Чин сүжигт номун хан эрдэнэ хамба ноён хутагтын нутгийн зургийг даавуун дээр өнгө ялган зурж, огнооны дээр тамга даржээ. Нутгийн зүүн талд Цэцэрлэгийн голыг зураад дөрвөн этгээдэд хэдий хэмжээний ямар газруудаар бусад хошуудтай зах нийлж буйг тодорхойлон бичжээ. Үүнд, Хувын сайрын амаас Байдраг голын зүүн эрэг барьсаар Өртөнттээлийг өгсөж Асгатыг дайран Эгийн даваан хүрүүлэн 160 газар(92 км 160м) сайд жанжин Эрдэнэ чин вангийн хошуутай, Эгийн давааны урдах хяр барьсаар Хөх нуур, Ар бөөрөг дайран Цохиотын даваанд хүрүүлэн 60 газар(34 км 560м) жанжин чин ван Наянтын хошуутай, Цохиотын давааны эхний урд нуруу барьсаар Хөх даваа, Хүрд баруун нуруу, Цэцэрлэгийн гол, Өлзийт гол уруудаж Босго, Талын ар барьсаар Цагаан хадын ус, Харчулуутын даваа, Хавчиг сүүжийн даваа, Хувын арын амны тус Байдраг голд хүрүүлэн 130 газар(74 км 880м) Цогтой түшээ гүн Дашдоржийн хошуутай зах нийлэн нутаглана хэмээв.

Мөн өмнөд этгээдийн Хувын сайраас хойд этгээд Эг даваа хүртэл 130 газар(74 км 880м), зүүн этгээд Эг даваанаас баруун зах Байдраг гол хүртэл 110 газар(63 км 360 м) байжээ.²³ Олноо өргөгдсөний 11-р(1921) оны 5 сарын шинийн 1-нд бичсэн өргөх цэсд “Сайн ноён хан аймгийн Үнэн ачит мэргэн сэцэн саруул номч бэлигт ухаант сайн Чин сүжигт номун хан эрдэнэ хамба ноён хутагтын шавь нарын нутаг нь Зүүн этгээдийн Их

²⁰ Сайн ноён хан аймгийн Эрдэнэ бандида хутагтын шавь нарын нутгийн зураг. МУҮНС. ГБС.

²¹ Сайн ноён хан аймгийн Төрөлх нэвтэрхий номч бишрэлт шадар үйзэн хурц сэргэлэн Эрдэнэ бандида хутагтын шавь нарын нутгийн зураг. МУҮНС. ГБС.

²² Монгол Улсын Үндэсний Төв Архив. Ф№М1.Т№1.ХН№2981.

²³ Сайн ноён хан аймгийн Ухаант сайн чин сүжигт номун хан эрдэнэ хамба ноён хутагтын нутгийн зураг. МУҮНС. ГБС.

цохиотын эхний хяр барьсаар Хөх даваа Хүрдийн баруун нуруу барьсаар тус Цагаан цэцэрлэгийн гол уруудаж Өлзийт гол Босгын ам, Талын ар, Цагаан хадын ус, Хар чулуутын даваа, Хавчиг сүүжийн даваа, Хар сайрын зүүн нуруу барьсаар Хувьн амны тус Байдрагийн гол хүртэл 130-ны газар(74 км 880 м) нэг аймаг хамаарсан чуулганы дарга Цогтой Түшээ гүнгийн хошуутай сав нийлмүй. Тэндээс Байдрагийн голын зүүн эрэг барьсаар Өртөнтийн гол өнгийж Асгат түрүү, Эгийн улаан чулуут хүртэл 160-ны газар(92 км 160 м) нэг аймаг жанжин Эрдэнэ чин вангийн хошуутай сав нийлмүй”²⁴ гэх зэргээр дэлгэрэнгүй бичсэн байдаг нь нутгийн зурагт тэмдэглэсэнтэй тохирч байна.

Олноо өргөгдсөний 3-р (1913) онд үйлдсэн Нарбанчин хутагтын шавь нарын нутгийн зургийг даавуун дээр 12 нүд бүхий улаан дөрвөлжин хүснэгтэд багтаан зурж тамга даржээ. Нутгийн төв хэсэгт Чандмань Соёлыг бадруулагч сүмийг дүрслэв. Бусад зургийн адил дөрвөн зүгийг тэмдэглээд баруун талын Завхан голын Дэлгэрбулангаас Номхон(Номгон?) зэрэг уулсын араар Завхан голын тэртээх Ямаат хэмээх уулыг дайран Хүрэнцонж хэмээх уулыг овоонд хүрүүлэн нэгэн аймгийн бэйс Ядамжавын хошуутай зах нийлэн нутагладаг хэмээжээ. Мөн өмнөд Хүрэнцонжийн овооноос Завхан голын эргээр Дэлгэрбуланд хүргүүлэн Засагт хан Цэрэнгомбожавын хошуутай зах нийлж нутаглах бөгөөд зүүн талын Шар хэмээх газраас баруун этгээдийн Номхон хэмээх ууланд хүртэл бүгд 120 газар(69 км 120 м), өмнө этгээдийн Завхан голоос хойд этгээдийн Туулайт хэмээх уул хүртэл бүгд 30 газар(17 км 280 м) хэмээн тооцон тэмдэглэжээ.²⁵

Олноо өргөгдсөний 11-р (1921) оны 5 сарын 21-нд үйлдсэн Сайн ноён аймгийн Нарбанчин хутагт шавь нарын нутгийн зургийг цаасан дээр өнгө ялган зурж тамга дарсан байна. 1913 оны зурагтай харьцуулахад маш тодорхой зурснаараа илт ялгагдах бөгөөд сүм, тамгын гэр, овоо, худаг, замыг зурав. Жишээ нь, “Хүчнийг бадруулагч сүм”, Бортолгой худаг, Цагаантолгойн худаг гэх мэт. Нутгийн захыг хүрээлэн баруун этгээдээс нар зөв ороон аль газраас аль газар хүртэл ямар хэмжээтэйг бичжээ. Үүнд, Энэ Дэлгэрбулангаас Номхон хүртэл 10-ны газар(5 км 760 м), үүнээс Гэээгийн хяр хүртэл 23-ны газар(13 км 248 м), үүнээс Хэрдийн хяр хүртэл 15-ны газар(8 км 640 м), үүнээс Туулайтын хяр хүртэл 15-ны газар(8 км 760 м), үүнээс Билүүт уртыг дайруулан Салхит булаг хүртэл 25-ны газар(14 км 400 м), үүнээс Хүрэн толгой хүртэл 20-ны газар(11 км 520 м), үүнээс Балгастайн гол хүртэл 25-ны газар(14 км 400 м), үүнээс Ямаат газрын хяр хүртэл 35-ны газар(20 км 160 м), үүнээс Талын хоёр бууцыг дайран Борцонж хүртэл 20-ны газар(11 км 520 м), үүнээс Цахиурт толгойг дайран Дэлгэрбулан хүртэл 120 газар(69 км 120м), эдгээр бүгд 308-ны газар(177 км 408 м) болмуй”²⁶ хэмээжээ. Мөн “Баруун этгээдэд Дэлгэрбулангаас зүүн этгээдийн Шар хөтөл хүртэл Хошууч бэйсийн хошуутай, Борцонжоос Завхан голын тэртээ ирмэгээр сайд Засагт ханы хошуутай сав нийлнэ” хэмээн бичсэн байна. Хойд талд “энэ Туулайтын овоо сав” хэмээсэн бол өмнө талд “зүүн этгээд Шараас баруун этгээд Номхон хүртэл эрс чигээр 120-ны газар(69 км 120м), Өмнө этгээд Борцонжоос хойд этгээд Туулайт хүртэл эрс чиг 30-ны газар(17 км 280м)” хэмээн тэмдэглэжээ. 1921 оны 5 сарын 21-ны өргөх цэст “энэхүү нутгийн зүүн этгээд Шараас баруун этгээд Номхон хүртэл эрс чигээр 120 газар(69 км 120 м), өмнө этгээд Борцонжоос хойд этгээд Туулайт хүртэл эрс чигээр 30-ны газар(17 км 280м)”²⁷ хэмээв. Энэ хэмжээг эрдэмтэн О.Пүрэв дээр дурдсан бүтээлдээ тодорхойлохдоо Завхан голоос хэмээн бичсэний учрыг нягтлууштай юм. Дилав хутагт Б.Жамсранжав Нарбанчин хутагтын шавь нарын нутгийг “баруунаас зүүнээ 50 бээр, хойноосоо өмнөө хүртэл 25 бээр хэмжээний нутаг байв. Түүний хил нь чулуун цацаар тэмдэглэгдсэн байжээ. Тэр нутгийн хойд хэсэг тэр чигээрээ намхан уулс байх агаад урагшлах тусмаа тэгш тал хээр болж, урд

²⁴ Өргөх цэс. Сайн ноён хан аймгийн Үнэн ачит мэргэн сэцэн саруул номч бэлигт ухаант сайн чин сүжигт номун хан эрдэнэ хамба ноён хутагтын шавь нарын нутаг нь. МУҮНС. ГБС.

²⁵ Олноо өргөгдсөний 3-р онд үйлдсэн Нарбанчин хутагтын шавь нарын нутгийн зураг. МУҮНС. ГБС.

²⁶ Сайн ноён аймгийн Нарбанчин хутагт шавь нарын нутгийн зураг нь. МУҮНС. ГБС.

²⁷ Өргөх цэс. МУҮНС. ГБС.18462/97.

хилийг нь эмжин урсах Завхан голд тулж очдог байв.”²⁸ хэмээсний 1 бээрийг 2 км орчим хэмээн тооцвол баруунаас зүүнээ 100 км, хойноосоо өмнөө хүртэл 50 км орчим гэж үзжээ. Энэ нь хэмжээний хувьд нутгийн зурагт тэмдэглэснээс нэлээд зөрүүтэй байна. Харин чулуун цац гэдэг нь овоо бөгөөд нутгийн захыг зурагт илүү нарийн тэмдэглэсэн хэмээн үзүүштэй ажээ.

Зурагт тэмдэглэсэн Борцонж хэмээх газар нь 1773 оны Сайн ноён, Засагт хан аймгийн нутгийн завсар хил тогтоон хэлэлцэж хоёр аймгийн савлан суух нутаг газрын нэрийг бичсэний доторх “Бор цонж”²⁹ хэмээх нэр байдаг нь дээр дурдсан газар мөн бололтой. Мөн 1950 онд Дилав хутагтын зурсан Халхын Дилав Нарбанчин хоёр хутагтын шавийн нутгийн зураг нь 12 тэмдэглэгээ бүхий нэлээд нарийвчлал бүхий зураг юм.³⁰ Хутагт өөрөө тийнхүү зурсан байдал нь тэрбээр нутгийн зургийн талаар зохих мэдлэг чадвартай байсныг илтгэж байна.

Олноо өргөгдсөний 3-р (1913) онд тогтоон зурсан нутгийн зураг хэмээх гарчиг бүхий зураг нь Жалханз хутагтын шавь нарын нутгийн зураг байна. Уг зургийг 16 нүд бүхий улаан дөрвөлжин хүснэгтэд багтаан зурсан бөгөөд Буяныг бүтээх сүм, Дэлгэр мөрөн, барун талд Хадат халзан, зүүн талд Улаан толгойг зурж, нэрийг бичжээ. Дашлүнгийн бэлчирээс Соёотолгой хүртэл Ахай гүнгийн зэрэг засаг Цэрэндоржийн хошуутай, Дашлүнгийн бэлчирээс Хөх хөтөлийн булан хүртэл өмнөд этгээдэд Далай түшээ гүнгийн хошуутай, Соёотолгойгоос Хужиртын ам хүртэл сайд Дүүрэгч чин вангийн хошуутай савлана хэмээн тэмдэглэсэн байна.³¹ Олноо өргөгдсөний 11-р (1921) оны 9 сарын 10-нд үйлдсэн Засагт хан аймгийн Номун хан Жалханз хутагтын нутгийн зургийг 42 нүд бүхий улаан дөрвөлжин хүснэгтэд багтаан өнгө ялган зуржээ. Огнооны дээр тамга даржээ. Дэлгэр мөрөн, сүм зэргийг зурж, хойд талд хулганаас эхлэн нутгийн эргэн тойрон 16 зүгийг бичиж тэмдэглэжээ.³²

Олноо өргөгдсөний 11-р (1921) оны 9 сарын 21-нд үйлдсэн Засагт хан аймгийн Нэвтэрхий сайн самади багш Ялгуугсан хутагтын нутгийн зурагт “Хутагтын суусан газар”, сүм, тамгын газрыг зурж бичээд Хойд холбоо нуур, Хөх чулуут, Цагаан гол, Гол мод зэрэг газар усыг дүрслэн нэрсийг заримынх нь хэмжээг бичжээ. Нутгийн эргэн тойронд шарагчин үхэр зүг, зогсолтын зүг, хөх барс зүг, хөхөгчин туулай зүг гэх зэргээр “Нутгийн зураг үйлдүүлэх зүйл”-ийн дагуу зүгийн нэрсийг бичжээ.³³

Олноо өргөгдсөний 8-р (1918) оны 9 сарын шинийн 9-нд үйлдсэн Сайн ноён хан аймгийн Хамба хутагт номун ханы шавь нарын нутгийн зургийг даавуун дээр өнгө ялган зуржээ. Онцгой гагц мод, Баян-Уул, Ямаатын гол, Туна гол, Манустай зэрэг олон газрын нэрсийн зэрэгцээ нутгийн төвд “Буян баясгалант сүм”, шанзудба суусан газар, тамгын жасааг тэмдэглэв.³⁴ Олноо өргөгдсөний 11-р (1921) он 4 сарын шинийн 9-нөө үйлдсэн Сайн ноён хан аймгийн Хамба хутагт номун ханы шавь нарын нутгийн зургийг цаасан дээр улаан дөрвөлжингүүд бүхий хүснэгтэд багтаан уул, мод, ус, замыг өнгө ялган зуржээ. Зурагт Хамба номунханы шавьнарыг захирах тамга дарсан байна. Мөн “Буян баясгалант сүм”, тамгын өргөө, шанзудба суусан газрыг тэмдэглэж Жаргалант гол, Идэр голыг тодорхой дүрсэлж, нутгийн баруун талын 3 уулын овоог зурсан байна. Зүүн өмнө талд Тарвагатай³⁵ хэмээн бичжээ.

“Эрдэнэ мэргэн ноён хутагтын шавийн нутгийн зураг энэ болой” хэмээх цаасан дээр зурсан зурагт нутгийн төв хэсэгт Ноён хутагт суух газар, “Соёлыг бадруулагч сүм”,

²⁸ Дилав хутагт Б. Жамсранжав. Гадаад Монгол дахь Нарбанчин хийд // Дилав хутагт Б. Жамсранжав. Ариун сэтгэл авралын үндэс (Дуртгал, намтар, өгүүлэл). Хэвлэлд бэлтгэсэн Л. Чойжлсүрэн. УБ., 2000. 236-р тал.

²⁹ Монгол Улсын Үндэсний Төв Архив. Ф№М1.Т№1.ХН№2981.

³⁰ Herbert Harold Vreeland, III. Mongol community and kinship structure. Human Relations Area Files: New Haven, 1957. p.126

³¹ Олноо өргөгдсөний 3-р онд тогтоон зурсан нутгийн зураг. МУҮНС. ГБС.

³² Засагт хан аймгийн номун хан Жалханз хутагтын нутгийн зураг. МУҮНС. ГБС.

³³ Засагт хан аймгийн Нэвтэрхий сайн самади багш Ялгуугсан хутагтын нутгийн зураг. МУҮНС. ГБС.

³⁴ Сайн ноён хан аймгийн Хамба хутагт номун ханы шавь нарын нутгийн зураг. МУҮНС. ГБС.

³⁵ Сайн ноён хан аймгийн Хамба хутагт номун ханы шавь нарын нутгийн зураг. МУҮНС. ГБС.

тамга ба шанзудба суух газрыг зурж тэмдэглэжээ. Баруун этгээд Нарийны ус, хойд этгээдэд Ар сүүл толгой, зүүн этгээд Гүнхүрээ(Хүнхрээ?) гол, өмнө этгээдэд Хөшөөт хэмээн бичсэн бөгөөд нутгийн захын эргэн тойрон 4 газарт савын овоог зурсан нь бусад нутгийн зургаас зарим талаар онцлогтой юм. Мөн зургийн баруун хойд хэсэгт замыг зураад “урагш нэвтрэх алс их зам болой”³⁶ хэмээн бичжээ. Сайн ноён хан аймгийн Ёст бэйлийн хошууны нутгийн зурагт зах нийлсэн Эрдэнэ мэргэн ноён хутагтын шавь нарын нутгийн зургийг зурсан³⁷ нь сонирхол татаж байна. Харин Олноо өргөгдсөний 11-р он(1921) онд үйлдсэн Сайн ноён хан аймгийн Ёст бэйлийн хошууны нутгийн зурагт шавь нарын нутгийг зурсангүй бөгөөд өмнөх зурагт байхгүй засаг тайжийн суудаг өргөөг тэмдэглэжээ.³⁸ Уг жишээ нь тухайн үед нутгийн зураг үйлдсэн үеийн хошуу шавийн харилцааг хэрхэн ойлгож байсныг илтгэх баримтын хувьд зохих ач холбогдолтой билээ. Сайн ноён хан аймгийн Бишрэлт Эрдэнэ мэргэн ноён хутагтын шавь нарын нутгийн цэсд “нутгийн хойд зах Сүүлтолгойгоос Түрүү хүртэл 10-ны газар(5 км 760 м), мөн эхний Түрүүгээс Шанага дэрс хүртэл 10-ны газар(5 км 760 м)”³⁹ гэх зэргээр дэлгэрэнгүй бичсэн байдаг.

Олноо өргөгдсөний 11-р (1921) оны зуны дунд сарын 23-нд үйлдсэн Сэцэн хан аймгийн сайд Егүзэр хутагт Галсандашийн нутгийн зургийг цаасан дээр зурж огноон дээр Егүзэр хутагт эрдэнэ мэргэн хамбын шавьнарыг захирах тамга даржээ. Уул, ус, замыг өнгө ялган зурж нутгийн эргэн тойрон 25 газрын нэрсийг бичжээ.⁴⁰

Сэцэн хан аймгийн Зарлигаар зарсан зүүн өмнө хязгаарыг байцаан үзэж илбэн тохинуулах сайд Егүзэр ачит зан бадарсан эрдэнэ мэргэн хамба ялгуугсан чин зүтгэлт үнэн сүжигт номч хутагтын шавь нарыг захирах тамга барьж хэрэг шийтгэх шанзудба Одсэрээс харьяат нутгийн зах нийлсэн овоодын зүг зовхис нэр зэргийг тодохойлсон цэс⁴¹ нь дээрх нутгийн зурагтай адил огноотой байна. Нутгийн зурагт товч бичсэн бол цэсд дэлгэрэнгүй бичжээ. Тухайлбал, зурагт “Улхан харуулын Саруул гүн Дамдинжавын хошуу лугаа зах нийлсэн Хайлантайн Цагаан толгойн овоо, Улхан Баянадарга харуулын Саруул гүн Дамдинжавын хошуу лугаа зах нийлсэн Дархинтайн Цагаанхошууны овоо” хэмээсэн бол цэсд “Нэгдүгээр Хайлантайн Цагаан толгойн овооноос хоёрдугаар Дархинтайн Цагаан хошууны овоо хүртэл орлогоос мөнхийн зүг хорин газар(11 км 520 м)” гэх мэтчилэн овоо хоорондын зайг бичжээ. Цэсийн төгсгөлд “Харьяат нутгийн өмнө этгээд Хайлантайн Цагаан толгойн овооноос хойдох этгээдийн Хожгир тойромын хойдох овоо хүртэл эрс 72 газар 1 хувь(41 км 530 м), зүүн этгээдийн Цагаанхошууны баруун довцогийн овооноос баруун этгээд Хожуултайн нурууны хилийн овоонд хүртэл 160 газар(92 км 160 м) болмуй” хэмээв. Харин нутгийн зурагт нутгийн захад буй гол горхины нэр, уулын өндөр, зам зэргийг бичсэн байна. Жишээлбэл, Онон гол, Бэрхийн хилийн овоо өндөр 1 газар(576 м), мэнд мэдээний зам гэх зэрэг болно. Тус шавь нарын зураг дахь нутгийн захын тэмдэглэл нь түүхийн судалгааны бүтээлүүд дэх зургаас ялгаатай тул нутгийн зураг, цэсийг үндэслэн 1921 оны Егүзэр хутагтын шавь нарын нутгийн зургийг шинээр сэргээн зурах болон нутаг дэвсгэрийн өөрчлөлтийн шалтгаан, бодот хэрэгжилтийг нарийвчлан судлах шаардлагатай хэмээн үзнэ.

16-р (1926) онд үйлдсэн Хан Хэнтий аймгийн Егүзэр хутагтын шавийн нутгийн зургийг цаасан дээр зурсан бөгөөд 4 зүг чигийн тэмдэглэгээг тусад нь зуржээ. Нутгийн захыг 6 өнгөөр ялган хүрээлж, захын тэмдгүүдийн харалдаа улаанаар бичсэн байна. Уг зургийг Дотоод яаманд үйлдсэн ажээ.⁴² Егүзэр хутагтын шавийн захиргааг албан ёсоор

³⁶ Эрдэнэ мэргэн ноён хутагтын шавийн нутгийн зураг энэ болой. МУҮНС. ГБС.

³⁷ Сайн ноён хан аймгийн Ёст бэйлийн хошууны нутгийн зураг. МУҮНС. ГБС.969/96

³⁸ Сайн ноён хан аймгийн Ёст бэйлийн хошууны нутгийн зураг. МУҮНС. ГБС.975/96

³⁹ Landscapes Reflected in Old Mongolian Maps. Edited by FUTAKI Hiroshi and KAMIMURA Akira. Tokyo.2005.p.136.

⁴⁰ Сэцэн хан аймгийн сайд Егүзэр хутагт Галсандашийн нутгийн зураг. МУҮНС. ГБС.

⁴¹ Landscapes Reflected in Old Mongolian Maps. Edited by FUTAKI Hiroshi and KAMIMURA Akira.Tokyo.2005. pp.108-113.

⁴² Хан Хэнтий аймгийн Егүзэр хутагтын шавийн нутгийн зураг. МУҮНС. ГБС.

таган буулгасны дараа чухам ямар зорилгоор уг зургийг зурсныг нягтлан судлууштай.

Олноо өргөгдсөний 7-р (1917) онд үйлдсэн Шива ширээт хутагтын хуучин шинэ нутгийн зургийг 56 нүд бүхий улаан дөрвөлжин хүснэгтэд багтаан зурж Шива ширээт хутагтын шавьнарыг захирах тамга даржээ. Харин дөрвөн зүгийг гаргахдаа нутгийн байршлыг харгалзан зүүн хойш ташлуулан зуржээ. Нутгийг хөндлөн урсах гол, сүм, зүүн хойд Хөх даваа, өмнөд Нарстын даваа зэрэг газруудын нэрсийг бичээд уул, ой модыг хараар тодорхой дүрслэн зуржээ.⁴³ Харин овоог тусгайлан зурсан зүйл ажиглагдсангүй.

Засагт хан аймгийн Номун ханы шавь нарын нутгийн зургийг бид хараахан олж үзсэнгүй. Гэвч Олноо өргөгдсөний 11-р(1921) оны 9 сарын 25-нд бичсэн өргөх цэсд “Засагт хан аймгийн хутагт Номун ханы шавийн үүрд нутаглах нутгийн өмнө этгээд улаан морин зүг болох Зуслангийн эхний нурууг хярлан Бурхан буудай уулыг зүүн этгээд хүртэл Итгэмжит бэйс Дашцэрэн, Ёст бэйл Мишигдорж нарын хошуу лугаа зах нийлмүй. Мөнхүү Бурхан буудай уулын зүүн этгээдийн хяраас Уушиг шилийн худгийг дайрч Хадах гол, Өсөө нуруунд хүрч мөнхүү нуруу ирмэглэн Хөх сэрхийн баруун этгээд Далт хүрч эрс чигээр Хадахыг уруудан Бэгэр голыг гаталж Зараа толгойг дайран Бор айрагийн баруун захаар гарч мөнхүү зуслангийн эхний нуруу хүртэл сайд Засагт ханы хошуу лугаа зах нийлмүй. Өмнө этгээд улаагчин морин зүг болох Зуслангийн баруун нуруунаас умар этгээд хар хулганын зүг болох Хатуугийн нурууны зүүн этгээд хүртэл 97 газар(55 км 872 м), өрнө этгээд цагаагчин тахиа зүг болох Уушгийн дорно этгээд хөхөгчин туулайн зүг болох Зараа хүртэл 80-ны газар(46 км 80м), ээвэргүүгийн зүг болох Бурхан буудай уулын зүүн этгээдийн хяраас мөнхийн зүг болох Хатуу голын шилээр өгсөж эхний нуруу хүртэл 75 газар(43 км 200м). Мөн үүнээс оролтын зүг болох Зуслангийн нуруу хүртэл 67 газар(38 км 592м). Мөн үүнээс ээвэргүүгийн зүг болох Бурхан буудай уулын зүг зүүн этгээдийн Хар хүртэл 50 газар(28 км 800м). Үүнд тойрон овоо байгуулсангүй. Басхүү харьяат нутгийн доторх уул усны нэр өндөр , өргөн, нарийны хэмжээг тус тус бичиж түүний байдал дүрс хэмжээ хандсан гарсан орсон зүг чигийг тохируулан зурсан ба бас бэлчээр элсийг уг зааж тушаасан хэргийн ёсоор өнгөөр ялгажээ. Мөн харьяат хүрээ сүм, жич харьяат хутагтын суусан газар захиргааны газар хаа бүхийг нь зурагт оруулан зурснаас гадна эл нутгийн доторх төмөр утас зам уурхай, давсны нуур тариалан цөм үгүй болмуй”⁴⁴ хэмээснийг үндэслэвэл нутгийн зургийг зурж байсан тодорхой бөгөөд судлаачид уг тэмдэглэл болон бусад баримтад тулгуурлан нутгийн зургийг нь шинээр нарийвчлан зурж болохуйц юм.

Монголын зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийн зургийн асуудалд холбогдох зургууд бол Засагт хан, Сэцэн хан, Сайн ноён аймгийн нутгийн зургууд болно. Тэдгээр зурагт зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийг зуржээ.

Бадаргуулт төрийн 33-р (1907)оны 12 сарын 12-нд үйлдсэн Халхын Засагт хан аймгийн арван есөн засаг хошуу, хутагт, номун хан нарын гурван шавийн нутаг газар орны байдал төлвийг Бадаргуулт төрийн 17-р онд (1891) зураг цэс үйлдэж Их журган, жанжин хуувийн сайдуудтанаа тус тус мэдүүлэн хүргүүлсний ёсоор нэгэн дөрвөлжин хэмжээнд нэгэн зуун газар болгон бодож үйлдсэн нутгийн зурагт Жалханз хутагт, Ялгуугсан хутагт, Номун ханы суусан газрыг бичиж, нутгийн хилийг улаанаар тэмдэглэжээ.⁴⁵ Мөн Олноо өргөгдсөний 12-р(1922) оны 11 сарын 3-нд үйлдсэн Засагт хан аймгийн 20 засаг хошуу, 3 хутагтын шавийн нутагласан газар орны зурагт дээрхийн адил ерөнхийлөн зурж тэмдэглэв.⁴⁶

Бадаргуулт төрийн гучин гуравдугаар (1907) оны 9 сарын 17 хэмээх огноо бүхий Халхын Сайн ноён аймгийн хорин дөрвөн хошуу зургаан хутагтын шавийн нутгийн зургийг

⁴³ Шива ширээт хутагтын хуучин шинэ нутгийн зураг. МУҮНС. ГБС.

⁴⁴ Өргөх цэс.Засагт хан аймгийн хутагт Номун ханы шавийн үүрд нутаглах нутгийн. МУҮНС. ГБС.

⁴⁵ Халхын Засагт хан аймгийн арван есөн засаг хошуу, хутагт, номун хан нарын гурван шавийн нутаг газар орны байдал төлвийг Бадаргуулт төрийн арван долоодугаар онд зураг цэс үйлдэж Их журга, жанжин хуувийн сайдуудтанаа тус тус мэдүүлэн хүргүүлсний ёсоор нэгэн дөрвөлжин хэмжээнд нэгэн зуун газар болгон бодож үйлдсэн нутгийн зураг. http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III-Hs_or_0162_Teil1.

⁴⁶ Засагт хан аймгийн 20 засаг хошуу, 3 хутагтын шавийн нутагласан газар орны зураг. МУҮНС. ГБС.

тухайн газар орны байдал төлвийг Бадаргуулт төрийн 17-р(1891) онд зураг цэс үйлдэж Их журган(Гадаад Монголын төрийг засах явдлын яам), жанжин хуувийн сайдуудтанаа мэдүүлэн хүргүүлсний ёсоор нэгэн дөрвөлжин хэмжээнд 100 газар(57 км 600м) болгон бодон үйлдсэн ажээ. Уг зурагт тамгатай хутагтуудын шавь нарын нутгийг зурсны зэрэгцээ хошуу шавийн нутгийн зах нийлсэн овоодын тайлбарыг тодорхой бичжээ. Жишээ нь, ”Засагт хан аймгийн Түшээ гүнгийн зэрэг засаг тайж Дамдинабиша, Ялгуугсан хутагт, манай Сайн ноён аймгийн засаг тайж Бирварагчаа нарын гурван хошуу, шавийн зах нийлсэн Хөхчулуут улаан байцын овоо”, “Засагт хан аймгийн Ялгуугсан хутагт, манай Сайн ноён аймгийн хуувийн сайд жүн вангийн зэрэг бэйл Цэдэнсодном, хэбэй бэйсийн зэрэг гүн Дугаржав, засаг тайж Бирварагчаа нарын дөрвөн хошуу, шавийн зах нийлсэн Тарвагатайн уулын нуруу, Засагт хан аймгийн Түшээ гүнгийн зэрэг засаг тайж Жалцангомбоцэдэн, Ялгуугсан хутагт, манай Сайн ноён аймгийн хэбэй бэйсийн зэрэг гүн Дугаржав нарын гурван хошуу, шавийн зах нийлсэн Яруу голын улаан эрэг”, “Засагт хан аймгийн чуулганы дэд дарга Засагт хан Содномравдан, манай Сайн ноён аймгийн хэбэй бэйсийн зэрэг гүн Дугаржав, Нарбанчин хутагт нарын гурван хошууны зах нийлсэн Номхон уулын Завхан гол”, “Засагт хан аймгийн чуулганы дэд дарга Засагт хан Содномравдан, манай Сайн ноён аймгийн хэбэй бэйсийн зэрэг гүн Дугаржав, Нарбанчин хутагт нарын гурван хошууны зах нийлсэн Борцонжийн овоо”, “Засагт хан аймгийн чуулганы дэд дарга Засагт хан Сономравдан, манай Сайн ноён аймгийн хэбэй бэйсийн зэрэг гүн Дугаржав, Наран хутагт нарын 3 хошуу шавийн зах нийлсэн Онгочулууны овоо”, “Засагт хан аймгийн засгаас огцруулсан бэйсийн зэрэг гүн Юндэндорж, манай Сайн ноён аймгийн засаг тайж Чимэдбалжин, Эрдэнэ бандида хутагт нарын гурван хошуу, шавийн зах нийлсэн Харчулуутын овоо”, “Засагт хан аймгийн засгаас огцруулсан бэйсийн зэрэг гүн Юндэндорж, манай Сайн ноён аймгийн Эрдэнэ бандида хутагт нарын хоёр хошуу, шавийн зах нийлсэн Өвөргүний овоо”⁴⁷ хэмээн тэмдэглэжээ.

Бадаргуулт төрийн 33-р он(1907)оны зуны дунд сарын 29-нд үйлдсэн Халхын Сэцэн хан аймгийн хорин гурван засаг хошууны нутгийн зурагт Ялгуугсан хутагтын гэр, Өнө өглөгт сүм хэмээн бичив.⁴⁸ Харин Ялгуугсан хутагт, Егүзэр хутагтын шавь нарын нутгийг ялган зурсангүй ажээ. Олноо өргөгдсөний 12-р (1922) оны зуны сүүл сарын 10-нд үйлдсэн Сэцэн хан аймгийн 23 засаг хошуу шавийн нутгийн зурагт мөн тэмдэглээгүй байна.⁴⁹ Бадаргуулт төрийн 33-р (1907) оны зуны дунд сарын 25-нд үйлдсэн Халхын Сэцэн хан аймгийн бэйсийн зэрэг засаг Сансрайдоржийн хошууны нутгийн зураг⁵⁰, Хэвт ёсны 2-р (1910) оны хаврын тэргүүн сарын 24-нд үйлдсэн Халхын Сэцэн хан аймгийн бэйсийн зэрэг засаг Сансрайдоржийн хошууны нутгийн зурагт зөвхөн Ялгуугсан хутагтын суух гэрийг тэмдэглэжээ.⁵¹ Уг нутгийн зургийн өөр нэг онцлог бол даавууны бүх талбайг дүүргэн дөрвөлжин хүснэгт татсан байдал юм. Иймд Сэцэн хан аймгийн Ялгуугсан хутагтын шавь нарын нутгийг тодорхой хэмжээтэйгээр зурсээр ирсэн судалгааны эх сурвалжийг дахин нягтлууштай санагдана.

Хэвт ёсны тэргүүн (1909) оны 3 сарын 29-нд үйлдсэн Халхын Сайн ноён аймгийн хорин дөрвөн хошуу, зургаан хутагтын шавийн нутаг газар орны байдал төлвийг Бадаргуулт төрийн 17-р(1891) онд зураг, цэс үйлдэж Их журган, жанжин хуувийн сайдуудтанаа мэдүүлэн хүргүүлсний ёсоор нэгэн дөрвөлжин хэмжээнд 100 газар(57 км 600м) болгон бодон үйлдсэн

⁴⁷ Халхын Сайн ноён аймгийн хорин дөрвөн хошуу зургаан хутагтын шавийн нутаг газар орны байдал төлвийг Бадаргуулт төрийн арван долоодугаар онд зураг цэс үйлдэж Их журган, жанжин хуувийн сайдуудтанаа мэдүүлэн хүргүүлсний ёсоор нэгэн дөрвөлжин хэмжээнд зуун газар болгон бодон үйлдсэн нутгийн зураг. МУҮНС. ГБС.

⁴⁸ Халхын Сэцэн хан аймгийн хорин гурван засаг хошууны нутгийн зураг. http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_Hs_or_0100_Teil3

⁴⁹ Халхын Сайн ноён хан аймгийн 24 хшуу, 8 хутагтын шавийн нутаг газар орны байдал төлвийг Чин улсын Бадаргуулт төрийн 33-р онд зураг цэс үйлдэж мэдүүлсний ёсоор аядуулан нэгэн дөрвөлжин хэмжээнд 20 газар болгон бодож үйлдсэн нутгийн зураг. МУҮНС. ГБС.

⁵⁰ Халхын Сэцэн хан аймгийн бэйсийн зэрэг засаг Сансрайдоржийн хошууны нутгийн зураг. http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_Hs_or_0085

⁵¹ Халхын Сэцэн хан аймгийн бэйсийн зэрэг засаг Сансрайдоржийн хошууны нутгийн зураг. http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_Hs_or_0139

нутгийн зурагт мөн дээрхийн адил тэмдэглэв.⁵² Олноо өргөгдсөний 4-р (1914) оны 3 сарын 29-нд үйлдсэн Халхын Сайн ноён аймгийн хорин дөрвөн хошуу, найман хутагтын шавийн нутаг газар орны байдал төлөвийг Чин улсын Бадаргуулт төрийн арван долоодугаар (1891) онд зураг, цэс үйлдэж мэдүүлсний ёсоор аядуулан нэгэн дөрвөлжин хэмжээнд 20 газар(11 км 520м) болгон бодож үйлдсэн нутгийн зурагт тамгатай хутагтуудын шавь нарын нутгийг дүрсэлж хутагтуудын суусан газар, сүмүүдийг тэмдэглэн бичжээ.⁵³ Мөн Халхын Түмэнхэн номун хан Сайн ноён хан аймгийн харьяат гучин хоёр хошуу шавийн нутаг хязгаар зах савыг нарийвчлан байцааж тэмдэглэж байжээ.⁵⁴ 1914 онд үйлдсэн И. Я.Коростовец, В.Л. Котвич нарын Монгол улсын газрын зурагт зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийн захыг тодорхой тэмдэглэж, заримыг нь засаг хошуудын нутагт багтаан зурсан байдаг.⁵⁵

Монголын зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийн зураг үйлдсэнээр нутаг эзэмшлийн хувьд бүрэн тусгаарласан хэрэг бус бөгөөд тамгатай хутагтуудын шавь нарын нутгийн асуудал нь тухайн орон нутгийн газар зүйн байршил, ус, бэлчээр зэрэг нүүдлийн мал аж ахуй эрхлэх онцлог хийгээд шавь байгуулсан түүхэн нөхцөл байдал, улмаар хошуу шавийн түүхэн уламжлалт харилцаа холбоотой уялдсан нутгийн хэргийн зохицуулалттай холбоотой юм. Зарим тамгатай хутагтын шавь нарын хувьд шаардлагатай үед нутаг бэлчээрийг засаг хошуутай хамтран эзэмших хэлбэр ХХ зууны эхэн хүртэл хадгалагдсаар байсныг газрын зурагт тусгасан байна.

Тамгатай хутагтын шавь нарын нутгийн зураг хэмээсэн, огноо бүхий бүрэн зургийн хувьд 1907 оны зургууд хадгалагдан үлджээ. Жавзандамба хутагтын зарим шавь нарын тусгаар нутаг эзэмшлийн өвөрмөц хэлбэр нь тухайн нутаг орны байдалтай холбоотой байв. Жавзандамба хутагтын шавь хар Дархад ардын нутгийн зураг нь зах хязгаар дахь нутаг эзэмшлийн уламжлал болон Манжийн төрийн бодлогын хэрэгжилтийн онцлогтой холбоотой байна. Манжийн эрхшээлийн үеийн Монголын зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийн зургийг үзэхэд зөвхөн Жавзандамба хутагтын шавь хар Дархад ардын нутгийн зургийг улаан дөрвөлжин бүхий хүснэгтэд багтаан зуржээ.

Халхын Засагт хан, Сайн ноён аймгийн зах нийлсэн нутагт Засагт хан аймгийн 1 тамгатай хутагтын шавь нар, Сайн ноён аймгийн 4 тамгатай хутагтын шавь нар нутаглаж байсан бөгөөд зарим хутагтын шавь нарын нутгийн хил зах нь Манжийн хааны зарлигаар тогтоосон хоёр аймгийн нутгийн заагт хэвээр байсан тул төдийлөн өөрчлөгдсөнгүй байна. Жавзандамба хутагтын шавь хар дархад ардын нутгийг зурахдаа 2 ямх дөрвөлжинд 5 газар багтаан зурж, цэс үйлдэж байсан бол Халхын аймгийн зургийг 1 дөрвөлжинд 20, 100 газрыг багтаан зурж байв.

Монгол улсын үед 1 ямхад 25 газрыг багтаан зурахаар тогтоосон боловч зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийн зургуудад хүснэгтийн дөрвөлжин нүдийг адилгүй тоотойгоор хуваан зуржээ. Харин 16 чигийг тохиолдуулан хэмжин зурж, тодорхой цэс үйлдэх ёсыг заримдаа баримтлан үйлдэж байв.

Монгол улсын тамгатай хутагтын шавь нарын нутгийн зургийг үйлдэхдээ засаг хошуудын адилаар зарим дүрмийг боловсруулан дагаж мөрдүүлж байсны хэрэгжилт 1913 -1920-иод оны зургуудад тусчээ. Тамгатай хутагтын шавь нарын нутгийн зураг нь зөвхөн шавь нарын нутгийн, засаг хошуутай хамтатган зурсан, аймгийн нутгийн зурагт багтаан зурсан, улсын газрын зурагт нэгжийн хувьд зурсан, тусгай зорилгоор болон хожим

⁵² Халхын Сайн ноён аймгийн хорин дөрвөн хошуу зургаан хутагтын шавийн нутаг газар орны байдал төлөвийг Бадаргуулт төрийн арван долоодугаар онд зураг цэс үйлдэж Их журган, жанжин хуувийн сайдуудтанаа мэдүүлэн хүргүүлсний ёсоор нэгэн дөрвөлжин хэмжээнд зуун газар болгон бодон үйлдсэн нутгийн зураг. http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_E_Hs_or_0163_Teil1

⁵³ Халхын Сайн ноён аймгийн хорин дөрвөн хошуу, найман хутагтын шавийн нутаг газар орны байдал төлөвийг Чин улсын Бадаргуулт төрийн арван долоодугаар онд зураг цэс үйлдэж мэдүүлсний ёсоор аядуулан нэгэн дөрвөлжин хэмжээнд 20 газар болгон бодож үйлдсэн нутгийн зураг. МУҮНС. ГБС.

⁵⁴ Landscapes Reflected in Old Mongolian Maps. Edited by FUTAKI Hiroshi and KAMIMURA Akira. Tokyo. 2005. p.147.

⁵⁵ Карта Монголии. составленная по данным бывшего уполномоченного в Монголии И. Я.Коростовца, при участии В.Л. Котвича. Издание Картографического Заведения А. Ильина. С.Петербург. Масштаб 80 верст в дюйм. -1913-1914.

сэргээн санаж зурсан зэрэг хэдэн зүйл байна. Тэдгээр нутгийн зургуудын ихэнх нь нутгийг хил заагийг тэмдэглэхэд чиглэсэн бөгөөд цөөн зурагт нутгийн дотоод байдлыг тодорхой дүрсэлжээ. Ихэнх зурагт тухайн нутгийн 4 зүгийн дагуу зах хил, уул, ус, овоо, сүм, тамгын газрыг дүрслэн нэрийг бичсэн бол цөөн зарим зургийг нутгийн зураг үйлдүүлэх зүйлийн дагуу зуржээ. Ганц зурагт шавь нарын нутгийн зөвхөн хойд, урд тал, тэдгээрийн хооронд орших газрыг голлон тэмдэглэжээ.

XX зууны эхэн үеийн Монголын зарим тамгатай зарим хутагтын шавь нар нь засаг хошуудын нэгэн адилаар нутгийн зургийг зурж хэрэглэж байсан нь тэдний тухайн байдлын онцлог талыг харгалзан үзүүштэйг илтгэх бөгөөд тэрхүү байдал 1911 оноос хойш буюу Монгол улсын үед улам баталгаажсан. Зарим нутгийн зургийн мэдээг баримталбал, Монголын түүх бичлэгт хэвшин тогтсон зарим газрын зургийг тодорхой үеэр зааглан нарийвчлан судлаж, шинэчлэн зурах боломжтой төдийгүй цаашид бусад хошууны нутгийн зургуудтай харьцуулан судалж, зохих тайлбартайгаар Монголын түүхийн газрын зурагт тэмдэглэх нь чухал юм.